

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/004/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Говьсүмбэр аймаг</p> <p>2026 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Б.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2026.01.23 № 13
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4226050078

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт 55 арга хэмжээ бүхий ажил, үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн ажилласан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 95.3%-тай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>308,229,323.06</u>	<u>337,513,364.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,511,993.47	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	33,511,993.47	-
3121	Төгрөг	33,511,993.47	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	33,511,993.47	
33	АВЛАГА	444,150.17	36,203,077.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	391,270.08	
33300	Татаас, санхүүжилтийн авлага		36,198,275.35
335	Бусад авлага	52,880.09	4,802.00
3351	Байгууллагаас авах авлага	52,880.09	4,802.00
35	БАРАА МАТЕРИАЛ	274,273,179.42	301,310,287.32
351	Түүхий эд материал	131,259,782.72	142,160,598.15
35110	Тусгай зориулалттай материал	120,553,512.42	131,634,075.55
35130	Эм боох материал	10,706,270.30	10,526,522.60
354	Хангамжийн материал	143,013,396.70	159,149,689.17
35410	Бичиг хэргийн материал	10,769,490.50	13,377,190.50
35420	Аж ахуйн материал	12,032,621.20	12,052,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	120,000.00	3,585,000.00
35440	Түлш, шатах тослох материал	8,250,252.00	10,282,072.17
35450	Барилгын засварын материал	11,064,010.00	12,930,140.00
35460	Хүнсний материал	1,261,749.00	1,623,862.50
35470	Бусад хангамжийн материал	99,515,274.00	105,298,624.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,134,996,605.31</u>	<u>5,103,590,877.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,134,996,605.31	5,103,590,877.90
392	Биет хөрөнгө	4,524,443,697.67	4,503,005,085.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,275,582,972.06	4,275,582,972.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(558,203,336.25)	(684,964,231.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	396,046,237.44	813,893,737.44
39204	Хуримтлагдсан элэгдэл	(170,125,744.14)	(294,864,737.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	891,204,956.13	691,390,389.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(370,571,148.94)	(348,080,578.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,982,806.40	63,367,306.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,151,407.83)	(44,935,954.02)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	31,367,456.00	31,367,456.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	310,906.80	310,906.80
39215	Хуримтлагдсан элэгдэл		(62,181.36)
393	Биет бус хөрөнгө	610,552,907.64	600,585,792.84
39301	Програм хангамж	76,875,407.56	76,875,407.56
39302	Хуримтлагдсан элэгдэл	(27,856,499.92)	(37,823,614.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	561,534,000.00	561,534,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,443,225,928.37</u>	<u>5,441,104,242.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>(0.00)</u>	<u>1,300,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	1,300,000.00
413	Өглөг	(0.00)	1,300,000.00
4136	Бусад өглөг	-	1,300,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		1,300,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,443,225,928.37</u>	<u>5,439,804,242.57</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	5,443,225,928.37	5,439,804,242.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,043,648,160.11	1,043,648,160.11
51101	Өмч: - төрийн	1,043,648,160.11	1,043,648,160.11
512	Хуримтлагдсан үр дүн	3,650,081,223.21	3,646,659,537.41
51210	Өмнөх үеийн үр дүн	3,650,081,223.21	3,651,284,588.65
51220	Тайлант үеийн үр дүн		(4,625,051.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	749,496,545.05	749,496,545.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,443,225,928.37	5,441,104,242.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,361,160,019.88	4,204,202,400.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,017,286,139.88	562,509,198.15
120	Нийтлэг татварын бус орлого	1,017,286,139.88	562,509,198.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	508,643,069.94	562,509,198.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		10,120,153.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,014,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	508,643,069.94	549,375,045.15
120009	Бусад орлого	508,643,069.94	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,343,873,880.00	3,641,693,202.52
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,273,074,400.00	3,614,486,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,273,074,400.00	3,614,486,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,799,480.00	27,206,502.52
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,225,200.00	21,932,502.52
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,450,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,124,280.00	5,274,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,826,011,630.69	4,055,643,319.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,826,011,630.69	4,055,643,319.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,632,052,145.05	3,863,508,232.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,631,336,304.50	2,956,167,589.49
210101	Үндсэн цалин	1,420,872,642.18	1,623,264,815.68
210102	Нэмэгдэл	941,064,869.27	1,072,141,254.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,070,301.61	119,981,815.55
210104	Урамшуулал	209,328,491.44	137,656,034.26
210105	Гэрээт ажлын хөлс		3,123,669.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,316,214.90	67,243,598.22
210201	Тэтгэврийн даатгал	6,246,708.87	8,471,757.49
210202	Тэтгэмжийн даатгал	737,007.28	952,775.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	736,065.74	985,689.20
210204	Ажилгүйдлийн даатгал	232,558.62	337,435.84
210205	Эрүүл мэндийн даатгал	52,363,874.39	56,495,940.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,784,737.63	194,860,325.55
210301	Гэрэл, цахилгаан	22,962,448.56	34,170,848.68
210302	Түлш, халаалт	158,416,649.07	152,440,591.87
210303	Цэвэр, бохир ус	14,405,640.00	8,248,885.00
2104	Хангамж, бараа материалын зардал	201,905,278.69	121,067,399.20

210401	Бичиг хэрэг	13,710,500.00	16,287,100.00
210402	Тээвэр, шатахуун	81,259,620.00	85,113,074.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,503,708.00	9,648,354.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	390,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,804,748.00	9,688,871.20
210408	Бараа материал акталсны зардал	86,236,702.69	
2105	Нормативт зардал	27,471,155.40	3,493,584.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	950,820.40	367,247.70
210502	Хоол, хүнс	26,520,335.00	3,126,336.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,903,340.00	34,793,810.00
210604	Урсгал засвар	15,903,340.00	34,793,810.00
2107	Томилолт, зочны зардал	19,710,900.00	25,203,405.00
210702	Дотоод албан томилолт	19,710,900.00	25,203,405.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,143,941.00	16,915,543.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,927,080.00	11,045,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	608,376.00	4,593,613.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319,000.00	385,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	
210807	Газрын төлбөр	561,605.00	561,430.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	407,880.00	330,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	461,480,272.93	443,762,977.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,102,720.00	16,898,136.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,760,926.30	7,869,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	417,616,626.63	418,995,840.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,959,485.64	192,135,087.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,845,925.03	139,930,527.90
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	250,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	154,667,925.03	94,342,607.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		37,795,920.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,928,000.00	7,792,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,113,560.61	52,384,559.54
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	1,437,293.61	311,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,676,267.00	52,073,559.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	535,148,389.19	148,379,080.95
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	61,221.10	153,004,132.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	61,221.10	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		153,004,132.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(61,221.10)	(153,004,132.19)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	535,087,168.09	(4,625,051.24)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,343,873,880.00	3,641,693,202.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	10,050,153.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	10,050,153.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	10,050,153.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		10,050,153.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,343,873,880.00	3,641,693,202.52
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,273,074,400.00	3,614,486,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,273,074,400.00	3,614,486,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,799,480.00	27,206,502.52
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,225,200.00	21,932,502.52
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,450,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,124,280.00	5,274,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,354,339,375.00	3,703,069,330.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,354,339,375.00	3,703,069,330.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,156,057,714.39	3,474,555,968.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,650,564,669.00	2,971,424,566.00
210101	Үндсэн цалин	1,440,101,006.68	1,635,575,446.42
210102	Нэмэгдэл	941,064,869.27	1,075,083,880.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,070,301.61	119,981,815.55
210104	Урамшуулал	209,328,491.44	137,659,754.04
210105	Гэрээт ажлын хөлс		3,123,669.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,868,261.39	66,472,334.53
210201	Тэтгэврийн даатгал	6,246,708.87	7,710,271.77
210202	Тэтгэмжийн даатгал	737,007.28	952,775.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	736,065.74	1,072,988.80
210204	Ажилгүйдлийн даатгал	232,558.62	368,940.34
210205	Эрүүл мэндийн даатгал	53,915,920.88	56,367,358.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,784,800.00	194,860,325.55
210301	Гэрэл, цахилгаан	22,962,448.56	34,170,848.68
210302	Түлш, халаалт	158,538,151.44	152,440,591.87
210303	Цэвэр, бохир ус	14,284,200.00	8,248,885.00
2104	Хангамж, бараа материалын зардал	112,681,180.00	122,914,954.00
210401	Бичиг хэрэг	15,113,000.00	19,517,300.00
210402	Тээвэр, шатахуун	77,956,280.00	83,099,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,880,300.00	9,648,354.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,331,600.00	10,319,400.00
2105	Нормативт зардал	27,172,000.00	2,342,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	187,500.00
210502	Хоол, хүнс	25,372,000.00	2,155,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,725,884.00	48,949,740.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,991,184.00	7,359,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,177,000.00
210604	Урсгал засвар	17,734,700.00	40,413,740.00
2107	Томилолт, зочны зардал	19,772,900.00	25,203,405.00
210702	Дотоод албан томилолт	19,772,900.00	25,203,405.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,562,200.00	18,953,443.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,732,500.00	13,413,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	629,000.00	4,593,613.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319,000.00	385,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	
210807	Газрын төлбөр	561,700.00	561,430.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,925,820.00	23,434,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,217,120.00	16,676,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,708,700.00	6,758,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,281,660.61	228,513,362.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	193,168,100.00	139,930,527.90
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	154,668,100.00	94,342,607.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,000,000.00	37,795,920.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		7,792,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,113,560.61	52,073,559.54
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	1,437,293.61	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,676,267.00	52,073,559.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>38,339,169.63</u>	<u>-31,962,993.47</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,307,216.00	1,549,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,307,216.00	1,549,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,307,216.00	1,549,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,307,216.00	1,549,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-24,307,216.00</u>	<u>-1,549,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	14,031,953.63	-33,511,993.47
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,480,039.84	33,511,993.47
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,511,993.47	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,043,648,160.11	750,076,638.39	3,527,396,799.83	5,321,121,598.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			580,093.34	580,093.34
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,043,648,160.11	750,076,638.39	3,527,976,893.17	5,321,701,691.67
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(580,093.34)		(580,093.34)

C07	Тайлант үеийн үр дүн			122,104,330.04	122,104,330.04
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,043,648,160.11	749,496,545.05	3,650,081,223.21	5,443,225,928.37
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,043,648,160.11	749,496,545.05	3,650,081,223.21	5,443,225,928.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(220,555.45)	(220,555.45)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,043,648,160.11	749,496,545.05	3,649,860,667.76	5,443,005,372.92
D08	Тайлант үеийн үр дүн			(4,625,051.40)	(4,625,051.40)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,043,648,160.11	749,496,545.05	3,646,659,537.41	5,439,804,242.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
02	I. ОРЛОГЫН ДҮН	3,648,026,500.00	3,572,463,293.46	75,563,206.54	99%
120004101	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,500,000.00	10,050,153.00	5,449,847.00	0.00%
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,632,526,500.00	3,562,413,140.46	70,113,359.54	98%
19	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,648,026,500.00	3,624,536,853.00	23,489,647.00	99%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,960,819,900.00	2,960,819,900.00	0.00	100%
210101	Үндсэн цалин	1,343,977,700.00	1,635,575,446.42	(291,597,746.42)	121%
210102	Нэмэгдэл	1,306,996,300.00	1,064,479,214.04	242,517,085.96	81%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,272,500.00	119,981,815.55	75,290,684.45	61%
210104	Урамшуулал	114,573,400.00	137,659,754.04	(23,086,354.04)	120%
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,123,669.95	(3,123,669.95)	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,190,100.00	65,144,498.01	45,601.99	100%
210201	Тэтгэврийн даатгал	2,301,200.00	6,808,875.15	(4,507,675.15)	295%
210202	Тэтгэмжийн даатгал	316,400.00	846,728.88	(530,328.88)	267%
210203	ҮОМШӨ-ний даатгал	349,700.00	954,069.89	(604,369.89)	272%
210204	Ажилгүйдлийн даатгал	111,100.00	328,645.47	(217,545.47)	295%
210205	Эрүүл мэндийн даатгал	62,111,700.00	56,206,178.62	5,905,521.38	90%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,707,400.00	194,860,325.55	5,847,074.45	97%

210301	Гэрэл, цахилгаан	36,614,800.00	34,170,848.68	2,443,951.32	93%
210302	Түлш, халаалт	153,176,500.00	152,440,591.87	735,908.13	99%
210303	Цэвэр, бохир ус	10,916,100.00	8,248,885.00	2,667,215.00	75%
2104	Хангамж, бараа материалын зардал	125,478,200.00	116,914,954.00	8,563,246.00	93%
210401	Бичиг хэрэг	22,046,700.00	18,258,700.00	3,788,000.00	82%
210402	Тээвэр, шатахуун	83,099,900.00	83,099,900.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,952,600.00	9,648,354.00	3,304,246.00	74%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	399,100.00	330,000.00	69,100.00	82%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,979,900.00	5,578,000.00	1,401,900.00	79%
2105	Нормативт зардал	7,577,200.00	2,342,500.00	5,234,700.00	31%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	747,400.00	187,500.00	559,900.00	25%
210502	Хоол, хүнс	3,842,400.00	2,155,000.00	1,687,400.00	56%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,987,400.00	-	2,987,400.00	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,713,400.00	50,498,740.00	2,214,660.00	96%
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,977,000.00	8,908,000.00	2,069,000.00	81%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,499,100.00	1,177,000.00	322,100.00	78%
210604	Урсгал засвар	40,237,300.00	40,413,740.00	(176,440.00)	100%
2107	Томилолт, зочны зардал	36,340,600.00	25,203,405.00	11,137,195.00	69%
210702	Дотоод албан томилолт	36,340,600.00	25,203,405.00	11,137,195.00	69%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,226,100.00	14,953,443.00	12,272,657.00	55%
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	20,368,400.00	9,413,400.00	10,955,000.00	46%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,597,200.00	4,593,613.00	3,587.00	99%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385,000.00	385,000.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,314,000.00	-	1,314,000.00	0.0%
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	561,500.00	561,430.00	70.00	99%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,032,400.00	1,795,000.00	14,237,400.00	11%
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	16,032,400.00	1,795,000.00	14,237,400.00	11%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,941,200.00	139,930,527.90	16,010,672.10	90%
2132	Бусад урсгал шилжүүлэг	155,941,200.00	139,930,527.90	16,010,672.10	90%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	99,974,200.00	94,342,607.00	5,631,593.00	94%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	37,796,000.00	37,795,920.90	79.10	100%

	албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,171,000.00	7,792,000.00	10,379,000.00	43%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1.00	-	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	88	83	5	94%
620001	Удирдах ажилтан	2	2.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	81	77.00	4.00	95%
620003	Үйлчлэх ажилтан	5	4.00	1.00	80%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	I. ОРЛОГЫН ДҮН	27,206,502.52
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,932,502.52
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,274,000.00
	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	27,206,502.52
210102	Нэмэгдэл	10,604,666.00
210201	Тэтгэврийн даатгал	901,396.62
210202	Тэтгэмжийн даатгал	106,046.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	118,918.91
210204	Ажилгүйдлийн даатгал	40,294.87
210205	Эрүүл мэндийн даатгал	161,179.46
210401	Бичиг хэрэг	1,258,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,741,400.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	4,000,000.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	4,963,000.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	311,000.00
	III. БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Тус байгууллагад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 8 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 8,818.1 мянган төгрөгийн 3 алдааны залруулга хийгдсэн байна.

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны 52.9 мянган төгрөгийн НДШ авлагыг барагдуулсан боловч данснаас хасаж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг зөрчсөн

2. Бараа материалын тодруулгын тайланд бичиг хэрэг, сэлбэг хэрэгслийн материалаас орлогыг 3,887.4 мянга, зарлагыг 4,593.4 мянган төгрөгөөр илүү, нярвын бараа материалын тайланд барилгын завсар, аж ахуйн материалын орлогыг 229.4 мянга, зарлагыг 55.0 мянга, нийт 8,765.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн

3. Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд нярвын үндсэн хөрөнгийн тайлангаас тоног төхөөрөмжийн зарлагыг 2,008.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн

Залруулаагүй алдаа: Байхгүй

Санхүүгийн аудитаар зөрчил¹ илрээгүй болно.

Аудитаар илрүүлсэн алдааг завсрын аудитаар залруулсан ба материаллаг зөрчил илрээгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

3.2.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Шилэн дансны цахим хуудсыг шалгахад дараа зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 9,199.0 мянган төгрөгийн 2 тушаал, 7 гэрээг хугацаа хоцроож мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 6 дугаар зүйлийн 6.4.8-нд “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11-т “зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар” гэсэн заалтуудтай зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, хугацаа хоцроож мэдээлэхгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.3 Зөвлөмж өгөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говьсүмбэр айгмийн Цагдаагийн хэлтэс	3	8.8			3	8.8	3	8.8				
Дүн	3	8.8			3	8.8	3	8.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс	
							Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Говьсүмбэр айгмийн Цагдаагийн хэлтэс	1	-			1	-		
	1	-			1	-		
Дүн								
Нийт дүн	1	-			1	-		

Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	ОНӨҮГ								
3	Төсөл, хөтөлбөр								
4	ЗГТС								
5	ТТЗ								
6	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			